



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/771

Булган сум

**Биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XIV хуралдааны XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэн ховор, ховор амьтдын тархац нутагт өвс, тэжээл, хужир, давс бэлтгэн биотехникийн арга хэмжээний зардлын тооцоог хавсралтаар баталж, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга (М.Оюунбат), Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга (Т.Гомбосүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

2.Тус ажилд тогтмол хяналт тавьж, хамтран ажиллах гэрээ байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д даалгасугай.

3.Дээрх ажлыг зохион байгуулахад Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 7,500,000 (долоон сая таван зуун мянга), Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 7,500,000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
11 сарын 15-ний өдрийн А/77 дүгээр  
захирамжийн хавсралт

**Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын  
захиргаанд биотехникийн арга хэмжээнд шаардагдах төсвийн задаргаа**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгж бүрийн үнэ	Нийт үнэ
1	Давс	Тонн	2.7	1,500	4,050,000
2	Тэжээлийн будаа	Тонн	5	600,000	3,000,000
3	Шатахуун	л	166	2,610	435,000
4	Масло	л	1	15,000	15,000
<b>Нийт дүн</b>					<b>7,500,000</b>

**Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд  
биотехникийн арга хэмжээнд шаардагдах төсвийн задаргаа**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгж бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өвс	Тонн	10	560,000	5,600,000
2	Давс, Хужир	Тонн	4	475,000	1,900,000
<b>Нийт дүн</b>					<b>7,500,000</b>